



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 1939

Улаанбаатар хот

Онцгой комиссын шуурхай штабын үйл  
ажиллагааг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх стратегийн команд штабын дадлага сургуулийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор үйл ажиллагаанд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Онцгой комиссын шуурхай штабын шаардлагатай тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-д үүрэг болгосугай.

3. Шуурхай штабын үйл ажиллагаанд шаардагдах 1,898,800 (нэг сая дөрвөн зуун гучин найман мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2023 он ажил/захирамж

1123000118

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 02 сарын 16 ны өдрийн 189 дугаар  
захирамжийн хавсралт



ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ЭРЧИМЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төг)	Шаардагдах хэмжээ	Бүгд	
1.	Онцгой комиссын тэмдэг /солиулах/	ш	59,800	1	59,800	
2.	Дүүргийн Онцгой комиссын даргын ажлын зураг хэвлүүлэх	ш	350,000	2	700,000	
3.	Зөөврийн аппарат	ш	120,000	1	120,000	
4.	Зөөврийн интернет төхөөрөмж /дугаартай/	ш	350,000	1	350,000	
5.	Тоон гарын үсгийн токен төхөөрөмж, гэрчилгээ /2 жил/	ш	77,000	1	77,000	
6.	Хөлтэй самбар бичиг хэргийн	ш	460,000	1	460,000	
7.	Албан бланк	А5 бланк	ш	140	200	28,000
		Бичгийн цаас	боодол	20,000	4	80,000
		Фото цаас	боодол	12,000	2	24,000
Бүгд					1,898,800	